

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 07 сарын 22 өдөр

Дугаар: 17

Улаанбаатар хот

**2022 оны санхүүгийн төлөвлөгөөнд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1, 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл”-ийн 3.2, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, Гүйцэтгэх захирлын 2022 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод (журам) хэм хэмжээ”-ний 2.8.2-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолтой нийцүүлэн компанийн зах зээлийн үнэлгээг нарийвчлан тогтоохтой холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 11 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн 2022 оны “Санхүүгийн төлөвлөгөө”-нд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.

2. Нэмэлт, өөрчлөлт оруулсан төлөвлөгөөг компанийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд тусгаж, Шилэн дансны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг 2022 оны 7 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



З.ЭНХБОЛД

"ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ" ХК-ИЙН 2022 ОНЫ
САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	ҮЗҮҮЛЭЛТ	МӨР	ТӨЛӨВЛӨГӨӨ /мян.төг/
1	ОРЛОГЫН ДҮН	1=(1.1+...+1.5)	9,988,186.06
1.1	Төсвөөс урсгал санхүүжилт		-
1.2	Нийт даатгалын хураамж		5,796,966.36
1.3	Хөрөнгө оруулалт, үндсэн үйл ажиллагааны орлого		4,191,219.70
1.4	Бусад орлого		-
2	ДААТГАЛЫН ЗАРДАЛ	2=(2.1+...+2.4)	5,198,842.49
2.1	Нийт төлсөн нэхэмжлэл /нөхөн төлбөр/		520,873.67
2.2	Нөхөн төлбөрийн нөөц сангийн зардал		2,105,013.09
2.3	Гадаад шилжүүлэг /ОУ-ын ДД-ын зардал/		2,341,077.07
2.4	Даатгалын гэрээний зардал		231,878.65
	Нийт зардлын орлогод эзлэх хувь		38.81%
3	НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	3=4	3,876,315.93
4	Урсгал зардлын дүн	4=5+8+9	3,876,315.93
5	Бараа үйлчилгээний зардал	5=6+7	2,059,588.13
6	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	6=(6.1+...+6.4)	1,830,745.00
6.1	Үндсэн цалин		1,328,400.00
6.2	Унаа, хоолны хөнгөлөлт		59,065.00
6.3	Нэмэгдэл цалин, урамшуулал		340,680.00
6.4	Мэргэжилтэн ажиллуулах хөлс /Даатгалын төлөөлөгчдөд олгох урамшуулал/		102,600.00
7	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөгдөх шимтгэл	7=7.1	228,843.13
7.1	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөгдөх шимтгэл		228,843.13
8	Бараа үйлчилгээний бусад зардал	8=(8.1+...+8.19)-8.13	913,077.80
8.1	Засвар үйлчилгээний зардал /урсгал засвар/		18,300.00
8.2	Байрны түрээсийн төлбөр /түрээс бусад/		27,080.00
8.3	Ашиглалтын зардал		600.00
8.4	Дотоод албан томилго		36,000.00
8.5	Гадаад албан томилго /арга хэмжээ/		15,000.00
8.6	Бичиг хэрэг		8,090.00
8.7	Тээвэр шатахуун		19,040.00
8.8	Шуудан, холбоо		16,640.00
8.9	Ном хэвлэл авах		693.20
8.10	Элэгдлийн зардал		374,352.60
8.11	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл /БҮТЭЗ/ хангамжийн материал		3,542.00
8.12	Төлбөр хураамж, бусад төлбөр		81,635.00
8.13	Хөрөнгө оруулалтын зардал		42,393.00
8.14	Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ		63,500.00
8.15	Банк санхүүгийн байгууллагын хураамж		5,000.00
8.16	Мэдээлэл сургалт, сурталчилгааны зардал		215,885.00
8.17	Гадаад зочин төлөөлөгчийн зардал		5,000.00
8.18	Татвар ногдох орлогоос хасагдахгүй бусад зардал		14,720.00
8.19	Хуваарилагдаагүй зардал		8,000.00
9	Татаас ба урсгал шилжүүлэг	9=9.1	903,650.00
9.1	Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал		32,850.00
9.2	Байгалийн гамшиг, ослын үр дагаврыг бууруулах		-
9.3	Хувьцаа гаргахтай холбоотой зардал		870,800.00
10	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	10=1-2-3	913,027.64
11	Орлогын албан татварын зардал	11=1.3*10%	419,121.97
12	Татварын дараах ашиг (алдагдал)	12=10-11	493,905.67
13	АЖИЛЛАГСАД БҮГД	13=13.1+...+13.4	55
13.1	ТУЗ-н гишүүн, дотоод аудитын албаны ажилтнууд		11
13.2	Удирдах ажилтан		6
13.3	Гүйцэтгэх ажилтан		35
13.4	Үйлчлэх ажилтан		3